

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2022/40/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Аудитор: Х.Еркебулан Утас: 92921881 Цахим хаяг: erkebulankh@ audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Төлбөрийн акт.....	18
Байхгүй	Error! Bookmark not defined.
4.3 Албан шаардлага	18
4.4 Зөвлөмж	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgiu@audit.gov.mn

**БУГАТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.ЖАНДАУЛЕТ
ТАНАА**

᠒᠐᠒᠒.᠐᠒.᠒᠑ № ᠒᠑᠒
танай _____ -ны № _____ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ
Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Бугат сумын Ерөнхий боловсролын сургууль 2021 оны санхүүгийн тайлангаар үндсэн хөрөнгийн дансанд 1645.1 сая төгрөгийн, бараа материалын дансанд 121.3 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэж тайлагнасан боловч жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийхдээ 116.0 сая төгрөгийн бараа материал, 273.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг дутуу тоолсон, тооллогын бүртгэлийн дүнг санхүүгийн тайлан дахь бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, 26 дугаар зүйлийн 26.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2 дахь заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, толилуулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>128,319,180.97</u>	<u>127,611,958.88</u>
33	АВЛАГА	7,616,543.97	6,268,992.88
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	7,616,543.97	6,268,992.88
35	БАРАА МАТЕРИАЛ	120,702,637.00	121,342,966.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	512,499.00	512,499.00
354	Хангамжийн материал	120,190,138.00	120,830,467.00
35420	Аж ахуйн материал	102,718,941.00	102,718,941.00
35440	Түлш, шатах тослох материал	235,000.00	201,160.00
35460	Хүнсний материал	6,195,497.00	5,339,766.00
35470	Бусад хангамжийн материал	11,040,700.00	12,570,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,330,998,639.98</u>	<u>1,333,256,079.62</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,330,998,639.98	1,333,256,079.62
392	Биет хөрөнгө	1,290,998,639.98	1,293,256,079.62
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,282,810,173.55	1,330,960,173.55
39202	Хуримтлагдсан элэгдэл	(114,314,941.20)	(173,993,303.64)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	106,252,314.00	117,286,855.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(81,239,776.08)	(72,522,465.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	137,814,514.71	115,384,714.71
39208	Хуримтлагдсан элэгдэл	(77,479,999.96)	(60,816,249.92)
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,000,000.00	11,800,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,000,000.04)	(4,000,000.08)
39217	Ном	29,156,355.00	29,156,355.00
393	Биет бус хөрөнгө	40,000,000.00	40,000,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	40,000,000.00	40,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,459,317,820.95</u>	<u>1,460,868,038.50</u>

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	2,585,530.04
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	2,585,530.04
413	Өглөг	-	2,585,530.04
4136	Бусад өглөг	-	2,585,530.04
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	-	2,585,530.04
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,459,317,820.95	1,458,282,508.46
51	Засгийн газрын хувь оролцоо	1,459,317,820.95	1,458,282,508.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	476,976,577.00	476,976,577.00
51101	Өмч: - төрийн	476,976,577.00	476,976,577.00
512	Хуримтлагдсан үр дүн	(21,092,093.10)	(22,127,405.59)
51210	Өмнөх үеийн үр дүн	(21,092,093.10)	(21,092,093.10)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(1,035,312.49)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,003,433,337.05	1,003,433,337.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,459,317,820.95	1,460,868,038.50

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	817,700,900.00	1,304,713,348.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	479,775,900.00	82,858,741.00
120	Нийтлэг татварын бус орлого	70,608,700.00	82,858,741.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	70,608,700.00	82,858,741.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,608,700.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	82,858,741.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	409,167,200.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	409,167,200.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	337,925,000.00	1,221,854,607.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	304,277,900.00	1,126,997,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	304,277,900.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	1,126,997,400.00

**Баян-Өлгий аймгийн Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,993,207.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,993,207.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	33,647,100.00	89,864,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	33,647,100.00	89,864,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	700,488,508.25	1,305,748,660.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	700,488,508.25	1,305,748,660.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	698,788,508.25	1,285,174,600.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	557,185,780.00	824,569,047.49
210101	Үндсэн цалин	502,449,863.00	821,279,047.49
210104	Урамшуулал	39,888,884.00	3,290,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	14,847,033.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,900,407.25	235,270,633.54
210201	Тэтгэврийн даатгал	81,320,886.61	235,270,633.54
210202	Тэтгэмжийн даатгал	8,747,154.66	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,352,943.53	-
210204	Ажилгүйдлийн даатгал	1,597,012.13	-
210205	Эрүүл мэндийн даатгал	15,882,410.32	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,115,521.00	82,944,080.00
210301	Гэрэл, цахилгаан	689,701.00	7,341,800.00
210302	Түлш, халаалт	21,099,120.00	75,102,280.00
210303	Цэвэр, бохир ус	326,700.00	500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	682,800.00	4,693,357.00
210401	Бичиг хэрэг	181,800.00	1,059,907.00
210402	Тээвэр, шатахуун	77,200.00	791,607.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	148,000.00	957,593.00
210404	Ном, хэвлэл	275,800.00	311,250.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	410,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,163,000.00
2105	Нормативт зардал	2,847,800.00	38,303,181.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	289,900.00

Баян-Өлгий аймгийн Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	2,497,800.00	36,706,181.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	350,000.00	1,307,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,000,000.00
210604	Урсгал засвар	-	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	276,700.00
210702	Дотоод албан томилолт	-	276,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,800,000.00	2,945,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,345,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,800,000.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	256,200.00	95,171,701.36
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	256,200.00	10,770,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	84,401,301.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,700,000.00	20,574,060.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,700,000.00	19,824,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,700,000.00	19,824,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	749,460.10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	749,460.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	117,212,391.75	(1,035,312.49)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	117,212,391.75	(1,035,312.49)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	476,976,577.00	1,003,433,337.05	-21,092,093.10	1,459,317,820.95
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	476,976,577.00	1,003,433,337.05	-21,092,093.10	1,459,317,820.95
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				

Дахин илэрхийлсэн үлдэгдэл	476,976,577.00	1,003,433,337.05	-21,092,093.10	1,459,317,820.95
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
Тайлант үеийн үр дүн			-1,035,312.49	-1,035,312.49
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	476,976,577.00	1,003,433,337.05	-22,127,405.59	1,458,282,508.46

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,184,918,100.00	1,221,854,607.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,184,918,100.00	1,221,854,607.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,117,827,500.00	1,126,997,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,117,827,500.00	1,126,997,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,993,207.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,993,207.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,090,600.00	89,864,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,090,600.00	89,864,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,184,734,099.00	1,218,054,607.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,184,734,099.00	1,218,054,607.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,169,188,886.00	1,197,480,546.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	902,953,433.00	928,864,899.90
210101	Үндсэн цалин	756,730,536.05	833,905,299.90
210104	Урамшуулал	116,650,763.95	55,148,729.23
210105	Гэрээт ажлын хөлс	29,572,133.00	39,810,870.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	140,371,467.00	125,396,700.00
210201	Тэтгэврийн даатгал	96,060,167.00	88,242,100.00

Баян-Өлгий аймгийн Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	7,836,400.00	9,288,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,537,700.00	7,430,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,646,100.00	1,857,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	28,291,100.00	18,577,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,749,806.00	88,864,000.00
210301	Гэрэл, цахилгаан	2,359,047.00	2,950,000.00
210302	Түлш, халаалт	59,683,459.00	85,414,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,707,300.00	500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,165,100.00	4,775,407.00
210401	Бичиг хэрэг	727,200.00	1,025,307.00
210402	Тээвэр, шатахуун	685,800.00	791,607.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	351,500.00	1,039,593.00
210404	Ном, хэвлэл	528,900.00	345,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,100,000.00	410,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,771,700.00	1,163,000.00
2105	Нормативт зардал	42,394,200.00	37,793,540.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	328,500.00	289,900.00
210502	Хоол, хүнс	39,182,700.00	35,653,140.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,883,000.00	1,850,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	991,600.00	276,700.00
210702	Дотоод албан томилолт	991,600.00	276,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	600,000.00	2,945,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	2,345,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,963,280.00	7,563,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,963,280.00	7,563,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,545,213.00	20,574,060.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,064,200.00	19,824,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,064,200.00	19,824,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,055,420.00	749,460.10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,055,420.00	749,460.10
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,425,593.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,425,593.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	184,001.00	3,800,000.00

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	200,000.00	3,800,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	200,000.00	3,800,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	200,000.00	3,800,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	200,000.00	3,800,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(200,000.00)	(3,800,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(15,999.00)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,216,841,400.00	1,216,091,939.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,216,841,400.00	1,216,091,939.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,196,267,400.00	1,196,267,339.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	928,864,900.00	928,864,899.90
210101	Үндсэн цалин	833,905,300.00	833,905,299.90
210104	Урамшуулал	54,119,500.00	55,148,729.23
210105	Гэрээт ажлын хөлс	40,840,100.00	39,810,870.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	125,376,700.00	125,376,700.00
210201	Тэтгэврийн даатгал	88,242,100.00	88,242,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,288,700.00	9,288,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,430,900.00	7,430,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,857,700.00	1,857,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,557,300.00	18,557,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,864,000.00	88,864,000.00
210301	Гэрэл, цахилгаан	2,950,000.00	2,950,000.00
210302	Түлш, халаалт	85,414,000.00	85,414,000.00
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,082,200.00	4,082,200.00

Баян-Өлгий аймгийн Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	742,100.00	742,100.00
210402	Тээвэр, шатахуун	762,000.00	791,607.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,069,200.00	1,039,593.00
210404	Ном, хэвлэл	345,900.00	345,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,163,000.00	1,163,000.00
2105	Нормативт зардал	37,793,600.00	37,793,540.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	289,900.00	289,900.00
210502	Хоол, хүнс	35,653,200.00	35,653,140.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,850,500.00	1,850,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	276,700.00	276,700.00
210702	Дотоод албан томилолт	276,700.00	276,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,945,900.00	2,945,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,345,900.00	2,345,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,063,400.00	7,063,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,063,400.00	7,063,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,574,000.00	19,824,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,574,000.00	19,824,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,574,000.00	19,824,600.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,216,861,400.00	1,216,111,939.90
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,126,997,400.00	1,126,247,939.90
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,126,997,400.00	1,126,247,939.90
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	89,864,000.00	89,864,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	89,864,000.00	89,864,000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	94.00	86.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00

620002	Гүйцэтгэх ажилтан	45.00	47.00
620003	Үйлчлэх ажилтан	48.00	38.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	452.00	452.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	452.00	452.00
630001	Төрийн өмчит ЕБС	452.00	452.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	94.0	86.0
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	40.00	32.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	44.00	44.00
650010	Гэрээт ажилтан	10.00	10.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Үзүүлэлт	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4993207.00
УРСГАЛ ЗАРДАЛ	4993207.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4993207.00
Хангамж, бараа материалын зардал	693207.00
Бичиг хэрэг	283,207.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	410,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	4300000.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,300,000
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4993207.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	4993207.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,993,207.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркебулан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн эрхэм зорилго нь

- Сурах хүсэл эрмэлзэлтэй
- Амьдрах арга ухаантай
- Зөв сайхан бичигтэй иргэн болгон төлөвшүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын зөвлөлийн комисс нь байгууллагын үйл ажиллагаанд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж үйл ажиллагаанд гарч буй зөрчил, дутагдлыг арилгаж, шалгалтын мөрөөр тодорхой ажил зохион байгуулах, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, анги, байгууллагын тодорхойлсон эрсдэлийг нэгтгэн, байгууллагын эрсдэлийн үнэлгээг тогтоож, тайланг аймгийн Боловсролын газарт хүргүүлдэг байна.

Тус сургуульд 2021 онд Санхүүгийн хяналт, дотоод аудитын шалгалт хийж 219.0 мянган төгрөгийн акт тогтоосон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1282.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 19.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувиар буюу 13.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1.5 сая төгрөгөөр буюу 0.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	7616.6	6269.0	-1347.6
Урьдчилгаа	0.00	0.00	0.00
Бараа материал	120702.6	121343.0	640.4
Үндсэн хөрөнгө	1330998.6	1333256.0	2257.4
Нийт хөрөнгө	1459317.8	1460868.0	1550.2
Өр төлбөр	0.00	2585.5	2585.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1459317.8	1458282.5	-1035.3

Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	<u>1459317.8</u>	<u>1460868.0</u>	<u>1550.2</u>
---	-------------------------	-------------------------	----------------------

Мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 6.3 сая төгрөг болж 1.3 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь он дамжсан хувь хүмүүсээс авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 121.3 сая төгрөг болж 0.6 сая төгрөгөөр нэмэгджээ. Тайлант онд 120.7 сая төгрөгийн бараа материал худалдан авч үйл ажиллагаандаа 120.1 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1333.3 сая төгрөг болж 2.2 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 3.8 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 82.9 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй авч, 48.1 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж, үндсэн хөрөнгөнд 84.4 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Өр төлбөрийн данс үлдэгдэл 2.6 сая төгрөг болж нэмэгдсэн нь татварын шинээр үүссэн өглөг байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 476.9 сая төгрөг болж 1.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн 1.0 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1304.7 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 487.0 сая төгрөгөөр буюу 59.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, нэмэлт санхүүжилт байна.

Нийт зардал өмнөх оноос 605.2 сая төгрөгөөр буюу 86.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглахтай холбоотой зардал, хангамжийн бараа материалын зардал, норматив зардал, эд хогшил, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлэг зэрэг зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2021 оны анх батлагдсан төсөв 1140.1 сая төгрөг, тодотгосон төсөв 1216.8 сая төгрөг байна.

Тодотгосон төлөвлөгөө нь анх баталсан төлөвлөгөөнөөс 76.7 сая төгрөгөөр өссөн байна. Үндсэн цалин 62.0 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 15.6 сая төгрөг, урамшуулал 54.1 сая төгрөг, хангамж бараа материалын зардал 0.5 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 2.0 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 4.0 сая төгрөг, урсгал шилжүүлэг 17.5 сая төгрөгөөр нэмж, норматив зардлыг 79.0 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

Энэ нь анх баталсан төсөвт цалингийн зардлыг 62.0 сая төгрөгөөр, урамшууллыг 54.1 сая төгрөгөөр төсөвт дутуу суулгасантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1216.8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 1216.1 сая төгрөгийг зарцуулж, үдийн цайны зардлын хэмнэлтээс 0.7 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нийт төсвийн 76.4 хувийг цалин, 10.3 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 7.3 хувийг тогтмол зардал, 0.3 хувийг хангамж бараа материалын зардал, 3.2 хувийг норматив зардал, 0.3 хувийг эд хогшил худалдан авах, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, 0.6 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 1.6 хувийг урсгал шилжүүлэг тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн Боловсролын газраас 5.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авчээ. Үүнээс хангамж, бараа материалын зардалд 0.7 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 4.3 сая төгрөг, нийт 5.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Бугат сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд гүйцэтгэлээр нийт 1216.1 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан ба Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтад хамаарах үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад батлагдсан төсвийн 10 хувь 1.7 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй, Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Бугат сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд нийт 1221.5 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1216.1 сая төгрөгийн 119 мэдээллийг хугацаанд байршуулж, 12 мэдээллийг хугацаа хоцроож нөхөж байршуулсныг шалгаж үзэхэд мэдээллээ засаж байршуулсантай холбоотой байна. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш нийт 80.5 сая төгрөгийн 8 гүйлгээ гарсныг бүрэн байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд аудитаар шилэн данстай холбоотой 3 зөвлөмж өгөгдсөн ба зөвлөмжийг хэрэгжүүлж биелэлтийг Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021.12.14-ны 81 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 391.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 391.3 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Аудитаар 391.3 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөв. Үүнд:

1.Бугат сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд гүйцэтгэлээр нийт 1216.1 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан ба Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтын дагуу байгууллагын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатайгаас бусад тэвчиж болох урсгал зардал 17.5 сая төгрөгийн төсвийн 10 хувиар 1.7 сая төгрөгөөр хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.4.1, Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-т "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, санхүүгийн тайланг хуулийн хугацаанд ирүүлэх талаар зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

2. Сургуулийн захирлын 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/66 дугаар тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсгийг байгуулсан бөгөөд санхүүгийн тайлангаар үндсэн хөрөнгийн дансанд 1,645,138.1 мянган төгрөгийн, бараа материалын дансанд 121,343.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэж тайлагнасан боловч жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийхдээ 116,003.2 мянган төгрөгийн бараа материал, 273,627.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дутуу тоолсон, тооллогын бүртгэлийн дүнг санхүүгийн тайлан дахь бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулаагүй. Санхүүгийн тайланг хуулийн хугацаанаас 15 хоног хоцроож 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдөр ирүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, 8 дугаар зүйлийн 8.9.1, 26 дугаар зүйлийн 26.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2 дахь заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, толилуулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн тооллогыг дахин хянаж үлдэгдлийг баталгаажуулж зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Бугат сумын Ерөнхий боловсролын сургууль	2	391.3					2	391.3		
Нийт дүн		2	391.3					2	391.3		